



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/231

Мөрөн сум

Тэсийн голын Нүүдэлчид-2023" өв соёлын
наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 14 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөлд зочлох нэрлэсэн жилийн хүрээнд соёлын өвийг хамгаалах, соёлын биет бус өвийн үндэсний үнэт зүйлийг бэхжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Тэсийн голын нүүдэлчид-2023 өв соёлын наадам” эвент арга хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 6,7,8-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Тэсийн голын нүүдэлчид-2023 өв соёлын наадам” эвент арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. “Тэсийн голын нүүдэлчид-2023 өв соёлын наадам” эвент арга хэмжээг “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн хүрээнд өргөн цар хүрээтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (М.Хуягбаатар), Цагаан-Уул сумын Засаг дарга С.Гончигням, Цэцэрлэг сумын Засаг дарга Н.Анхбаяр нарт тус тус үүрэг болгосугай.


4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 11-ний өдрийн А/231
дүгээр захирамжийн хавсралт



**“ТЭСИЙН ГОЛЫН НҮҮДЭЛЧИД -2023 ӨВ СОЁЛЫН
НААДАМ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар-(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

- Б.Оюунтуяа-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- А.Алтанцоож (Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)
- Ё.Пүрэвсүрэн (аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
- П.Мөнхжаргал(аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- С.Гончигням (Цагаан-Уул сумын Засаг дарга)
- Н.Анхбаяр (Цэцэрлэг сумын Засаг дарга)
- Г.Энхбаяр (Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга)
- Б.Энхгэрэл (Дэлгэрмөрөн Шишгэд голын сав газрын захиргааны дарга)
- Я.Эрхэмбаяр (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- Б.Банзрагч-(Аймгийн Хөгжимт драмын театрын дарга)
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэлийн ажилтан
- Аймгийн Үндэсний бөхийн холбооны тэргүүн (тохиролцсоноор)
- Аймгийн Уяачдын холбооны тэргүүн (тохиролцсоноор)
- Аймгийн Үндэсний сурын холбооны тэргүүн (тохиролцсоноор)
- Аймгийн Шагaйн холбооны тэргүүн (тохиролцсоноор)

Нарийн бичгийн дарга:

Ж.Даваадамдин (Аймгийн соёл урлагын газрын дарга)

____оОо____